



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар А/6/

Пионер толгой

┌ Буйр бууц цэвэрлэх, бэлчээрийн сэг зэм ┐  
устгах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.4 дэх заалт, Хүнс, Хөдөө Аж ахуй, Хөнгөн Үйлдвэрийн сайдын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/206 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжөө, хаваржааны буйр бууцны ойр орчим, бэлчээрийн сэг зэмийн цэвэрлэгээг хийх ажлыг 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд хөдөөгийн 4 багийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар байгуулсугай.

2.Өвөлжөө, хаваржааны буйр бууцыг цэвэрлэх, бэлчээрийн сэг зэмийг устгах ажилд Засаг даргын Тамгын газрын байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлаас 5,468,000 (Таван сая дөрвөн зуун жаран найман мянган) төгрөгийг гарган зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

3.Өвөлжөө, хаваржааны буйр бууцыг цэвэрлэх, бэлчээрийн сэг зэмийг устгах ажлыг чанартай, үр дүнтэй зохион байгуулж тайлагнахыг баг тус бүрийн ажлын хэсгийн ахлагч, багийн Засаг дарга нарт хариуцуулсугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА



642201311  
2023/Засаг дарга/Захирамж2023

Сумын Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 29-ний өдрийн  
А/б/ дугаар захирамжийн хавсралт



БЭЛЧЭЭРИЙН СЭГ ЗЭМ УСТГАХ АЖЛЫГ БАГТ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

Цэнгэл 1 дүгээр багт:

|                                    |                                    |
|------------------------------------|------------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: Э. Сүглэгмаа | Засаг даргын орлогч                |
| Б.Лувсаншийрэв                     | Цэнгэл 1 дүгээр багийн Засаг дарга |
| Э.Хас-Очир                         | Мал эмнэлгийн Улсын байцаагч       |
| Б.Дэлгэрдалай                      | Нягтлан бодогч                     |
| Х.Бат-Эрдэнэ                       | Цагдаа                             |

Давааны ам 2 дугаар багт:

|                                |  |
|--------------------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: Ш.Нархүү | Байгаль орчны хяналтын Улсын байцаагч  |
| Д.Мөнхчулуун                   | Давааны ам 2 дугаар багийн Засаг дарга   |
| М.Ариунсан                     | Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт<br>малын үржил бүртгэл хариуцсан<br>мэргэжилтэн |
| Б.Мөнхдалай                    | Нийгмийн бодлогын мэргэжилтэн  |
| Б.Мөнх-Эрдэнэ                  | Олон нийтийн цагдаа  |

Буга 3 дугаар багт:

|                                  |                                  |
|----------------------------------|----------------------------------|
| Ажлын хэсгийн ахлагч: Р.Гантулга | Засаг даргын Тамгын газрын дарга |
| Д.Болд-Аюуш                      | Буга 3 дугаар багийн Засаг дарга |
| М.Бат-Эрдэнэ                     | Байгаль хамгаалагч               |
| Б.Няммэший                       | Сан хариуцсан нягтлан бодогч     |
| А.Баяртогтох                     | Үйлчлэгч                         |

Хөвийн ам 4 дүгээр багт:

|                                  |  |
|----------------------------------|--|
| Ажлын хэсгийн ахлагч: Б.Гантулга | Засаг дарга                                  |
| Ц.Номин-Эрдэнэ                   | Улсын бүртгэгч                               |
| Б.Баттулга                       | Хөвийн ам 4 дүгээр багийн Засаг дарга        |
| Ч.Батцэцэг                       | Пионер толгой 5 дугаар багийн Засаг<br>дарга |
| Х.Мядагдадам                     | Нийгмийн даатгалын байцаагч                  |